



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар A/35

Бат-Өлзий сум

Газар ашиглах эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт Рамын дэнж-3 316 тоот хаягт байрлах "Хан сэнтий" хязгаарлагдмал хариуцлагатай компани (РД:3552497)-ийн эзэмшиж буй 6221000510 нэгж талбарын дугаартай, үйлдвэрлэлийн зориулалттай 5823 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 40 жилээр, 5 дугаар багийн нутаг дэвсгэр Хүйтэнбулагт байрлах "Малчдын хамтын хүч" хоршооны эзэмшиж буй 6221002147 нэгж талбарын дугаартай, тэжээлийн ургамал тариалах зориулалт бүхий 2,4 га газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 40 жилээр тус тус сунгасугай.

2. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд газар ашиглах гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, газрыг зориулалтын дагуу ашиглаж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Бат-Өлзий сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн "Газар шинээр эзэмшүүлэх тухай" 51 дүгээр захирамж, Засаг даргын 2011 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн "Газар шинээр эзэмшүүлэх тухай" 23 дугаар захирамжийг тус тус хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН